



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Дотоод журам батлах тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 18.8, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 3.6, "Эрх олгох тухай" Цөмийн энергийн комиссын 2019 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход санал авах, санал өгөх дотоод журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд даалгасугай.

ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

0100063

Цөмийн энергийн комиссын 2023 оны
08 дугаар сарын 02 ны өдрийн 04
дугаар тогтоолын хавсралт

**ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮРТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД САНАЛ АВАХ,
САНАЛ ӨГӨХ ДОТООД ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дотоод журмын зорилго нь Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, хадгалах, тээвэрлэх, түрээслэх, импортлох, экспортлох, цацрагийн үүсгүүрийн хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид "тусгай зөвшөөрөл" гэх) олгоход мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.8-д заасны дагуу Цөмийн энергийн комисс (цаашид "Комисс" гэх)-оос санал авах, санал өгөх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход санал авах, санал өгөх харилцаанд Цөмийн энергийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон энэхүү дотоод журмыг мөрдөнө.

Хоёр.Тусгай зөвшөөрөл олгоход санал авах

2.1.Цөмийн энергийн комисс нь санал авахаар ирүүлсэн материалыг судлан үзэж, цацрагийн үүсгүүрийн ангилал, аюул эрсдэл зэргийг харгалзан дараах байдлаар санал өгнө.

2.1.1-2 дугаар ангиллын цацрагийн үүсгүүрийн тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой саналыг Цөмийн энергийн комиссын хуралдаанаар хэлэлцүүлж олгоно;

2.1.2.3-5 дугаар ангиллын цацрагийн үүсгүүр болон рентген аппарат, тоног төхөөрөмжүүдэд тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой саналыг Комиссын Нарийн бичгийн дарга эсхүл Комиссын Ажлын алба олгоно.

2.2.Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой санал авахад энэхүү журмын 2.4, 2.5-д заасан баримт бичгийг бүрдүүлэн portal.igov.mn цахим системээр Комиссын Ажлын албанд ирүүлнэ.

2.3.Комиссын Ажлын алба энэхүү журмын 2.1-д заасан санал авах арга хэмжээг зохион байгуулна.

2.4.Энэхүү журмын 2.1.1-д заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой санал авахад дараах баримт бичгийг цахим системээр хүргүүлнэ.

2.4.1.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл (албан бичиг);

2.4.2.Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.2, 19.1.3, 19.1.6, 19.1.7, 19.1.8, 19.1.9, 19.5-д заасан баримт бичиг;

2.5.Энэхүү журмын 2.1.2-т заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой санал авахад дараах баримт бичгийг цахим системээр хүргүүлнэ.

2.5.1.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл (албан бичиг);

2.5.2.Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.2, 19.1.3, 19.1.6, 19.1.7, 19.1.8, 19.1.9, 19.5-д заасан баримт бичиг;

2.5.3.Рентген аппарат, тоног төхөөрөмжийг импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл олгоход Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 болон худалдан авах гэрээний хуулбар, эцсийн хэрэглэгчийн мэдээлэл.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход санал өгөх

3.1.Комиссын Ажлын албанаас энэхүү журмын 2.4-т заасан тусгай зөвшөөрлийн баримт материалд үнэлгээ хийх бөгөөд Комиссын Нарийн бичгийн дарга нь Комиссын хуралдаанаар хэлэлцүүлж, санал авна.

3.2.Гамшгийн онцгой нөхцөл байдал, нийтийн эмх замбараагүй байдал, онц байдал зарласан үед энэхүү журмын 2.1.1-д заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой саналыг ажлын шугамаар Комиссын гишүүдээс авч шийдвэрлэж болно.

3.3.Комиссын Ажлын албанаас энэхүү журмын 2.5-д заасан тусгай зөвшөөрлийн материалд үнэлгээ хийх бөгөөд Комиссын Нарийн бичгийн дарга үнэлгээ, баримт материалыг хянаж үзээд тусгай зөвшөөрөл олгоход санал өгнө.

3.4.Комиссын Нарийн бичгийн дарга энэхүү журмын 3.3-д заасан тусгай зөвшөөрөл олгоход өгсөн саналын талаарх мэдээллийг улирал тутам Комисст танилцуулна.

3.5.Энэхүү журмын 3.1-3.3 дахь заалтын хүрээнд шийдвэрлэсэн саналыг Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад portal.igov.mn цахим системээр хүргүүлнэ.

3.6.Комиссоос Цөмийн энергийн тухай хуулийн 15.3.1, 15.3.2, 15.3.4-т заасан тусгай зөвшөөрөл олгох саналыг ажлын 10 хоногийн дотор, 15.3.3-т заасан тусгай зөвшөөрөл олгох саналыг ажлын 3-5 өдрийн дотор өгнө.

3.7.Комиссын Ажлын албанаас Цөмийн энергийн тухай хуулийн 15.3-т заасан тусгай зөвшөөрөл олгох саналыг ажлын 3 өдрийн дотор өгнө.

Дөрөв. Бусад

4.1.Цөмийн энергийн тухай хуулийн 32.3.1-т заасан үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх үндсэн шаардлагыг хангах зорилгоор 10 жилээс их насжилттай эмчилгээ, оношилгооны рентген аппарат, төхөөрөмжийг импортлохгүй байх чиглэл баримтална.

4.2.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад санал авахгүй.

4.3.Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олгосон зөвшөөрлийн талаарх тайлан мэдээллийг Комисст болон Тагнуулын төв байгууллагад улирал тутам хүргэнэ.

4.4.200 кВ ба түүнээс бага хүчдэл үүсгэх рентген аппарат, тоног төхөөрөмжийг 1 дүгээр ангиллын, түүнээс их хүчдэл үүсгэх рентген аппарат тоног төхөөрөмжийг 2 дугаар ангиллын рентген төхөөрөмжид хамруулан аюулгүй ажиллагааны шаардлагуудыг хангуулна.

xxxXXXxxx